

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГА

Д.ГАНХҮҮ

ГҮЙЦЭТГЭГЧ
“МОНГОЛЫН ҮНЭТ ЦААС ХЭВЛЭЛ”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Э.АРИУНГЭРЭЛ

ХЭВЛЭЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГЭРЭЭ

Дугаар 2021/105

2021 оны 05 дугаар сарын

do өдөр

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү гэрээг нэг талаас Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар /цаашид “захиалагч” гэх/, нэгөө талаас “Монголын үнэт цаас хэвлэл” ХХК /цаашид “гүйцэтгэгч” гэх/ /хамтад нь “талууд” гэх/ дараах нөхцөлийг харилцан тохиролцож, 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаагаар байгуулав.

1.2. Энэхүү гэрээгээр гүйцэтгэгч нь захиалагчийн захиалсан техникийн тодорхойлолтын дагуу хэвлэх ажлыг чанар, дизайны өндөр түвшинд гүйцэтгэж, хүлээлгэн өгөх, захиалагч гэрээгээр тохирсон төлбөрийг төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.3. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ.

1.4. Талууд албан бичиг болон баталгаат цахим шуудангаар гэрээтэй холбоотой асуудлаар харилцана.

1.5. Гэрээ нь дараах хавсралттай байх ба тэдгээр нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна. Үүнд:

1. Гэрээний ерөнхий нөхцөл.
2. Гэрээний тусгай нөхцөл.
3. Барааны техникийн тодорхойлолт.

Хоёр. Гэрээний талуудын эрх үүрэг


2.1. Захиалагчийн эрх, үүрэг:

2.1.1. Гүйцэтгэгчид барааны төрөл, тоо ширхэг, дугаарлалт заасан албан тоотоор захиалга өгөх.

2.1.2. Барааг хэвлэх явцад захиалагчийн зүгээс хянах, зөвлөх үүрэг, хариуцлага бүхий этгээдийг ажлын талбайд ажиллуулах эрхтэй.

2.1.3. Гэрээгээр тохирсон ажлын хөлсийг хугацаанд нь шилжүүлэх.

2.1.4. Гүйцэтгэгчээс гэрээний үүргээ хугацаандаа, зохих ёсоор, чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг шаардах.



2.1.5. Батлагдсан эх загвараас гажсан, захиалагчийн шаардлага хангагүй, алдаатай, буруу, нууцлаагүй хэвлэсэн тохиолдолд гэрээг дангаараа цуцлах эрхтэй.

2.2. Гүйцэтгэгчийн эрх үүрэг:

2.2.1. Захиалагчийн баталсан эх загвар, энэхүү гэрээний 1.4-д заасны дагуу захиалга хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор чанарын өндөр түвшинд хэвлэх.

2.2.2. Батлагдсан эх загвараас гажсан, захиалагчийн шаардлага хангагүй, алдаатай, буруу, нууцлалгүй хэвлэсэн тохиолдолд өөрийн зардлаар дахин хэвлэж гэрээгээр тогтоосон хугацаанд хүлээлгэн өгөх.

2.2.3. Ажил гүйцэтгэх явцад гарсан зарим эргэлзээтэй болон шаардлагатай зүйлийн талаар тухай бурд нь захиалагч талд мэдэгдэх.

2.2.4. Гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэхгүй байх бөгөөд ажлыг туршлагатай, чадварлаг ажилтнаас бүрдсэн багаар гүйцэтгүүлнэ.

2.2.5. Гүйцэтгэгч нь захиалагчаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

2.2.6 Гүйцэтгэгч нь захиалагчийн зөвшөөрөлгүйгээр барааг хувилан олшууллах, бусад этгээдэд барааг дамжуулахыг хориглоно.

Гурав. Талуудын хүлээх хариуцлага

3.1. Гүйцэтгэгч нь захиалагчийн зөвшөөрөлгүйгээр хэвлэсэн, худалдсан, бусдад өгсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд захиалагч тал гэрээг дангаараа цуцалж, хууль тогтоомж зөрчсөн эсэхийг хуулийн байгууллагад хүсэлт гаргаж шалгуулна.

3.2 Ажлын доголдлыг арилгах талаар гүйцэтгэгч тогтоосон хугацаанд ямар нэг арга хэмжээ аваагүй бол захиалагч уг доголдлыг арилгаж, түүнтэй холбогдсон зардлаа гүйцэтгэгчээр нөхөн төлүүлнэ.

Дөрөв: Төлбөр

4.1. Газрын кадастрын зураглал хэвлэх үнэт цаасны нэг бүрийн үнэ 220 /НӨАТ-тай үнэ/ төгрөг, нэгж талбарын хувийн хэргийн хавтасны нэг бүрийн үнэ 1430 /НӨАТ-тай үнэ/ төгрөг тус тус байна.

4.2. Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувиар алданги төлнө.

Тав. Бусад


5.1. Талууд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

5.2. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай бол талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

5.3 Талууд харилцан тохиролцож гэрээний хугацааг 1 хүртэлх жилээр сунгаж болно.

5.4. Гэрээнд орсон нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга, /тэмдэг/ дарж баталгаажуулнаар гэрээ хүчин төгөлдөр болно.

5.5. Гэрээг 3 хувь үйлдэв. / Хувиуд адил хүчинтэй ба талууд тус бүр 1 хувийг авав/



5.6. Энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЗАХИРГАА, УДИРДЛАГА, ХАМТЫН АЖИЛГААНЫ ГАЗРЫН ДАРГА

Р.ГАНХУЯГ

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Л.ЛУВСАН

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН ДАРГА

П.БАЯНТУМЭН

ХАЯГ: МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 2-Р ХОРОО,
БАРИЛГАЧДЫН ТАЛБАЙ-3, ЗАСГИЙН
ГАЗРЫН XII БАЙР, 1 ДАВХАР, 125 ТООТ

УТАС: 260785

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"МОНГОЛЫН ҮНЭТ ЦААС ХЭВЛЭЛ" ХХК-ИЙН МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР

Т.АМАРЖАРГАЛ

ХАЯГ: УЛААНБААТАР ХОТ, ХАН-УУЛ ДҮҮРЭГ, 3-Р ХОРОО, АЖИЛЧНЫ ГУДАМЖ-

133/2

УТАС: 70140459

